



**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 03 сарын 22 өдөр

Дугаар 27

Даланзадгад

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2008 оны 11 дүгээр тогтоолоор батлагдсан “Хурлын даргын нөөц хөрөнгө зарцуулах журам”-ын 2.5 дахь заалт, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн ажлын албаны 2019 оны ажлын төлөвлөгөөг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ НЬ:**

1. Гадаад, дотоодын зочид, төлөөлөгчдийн гарын бэлэг, дурсгалын зүйлд зориулж Даланзадгад сумын ахмад настан А.Цоожийн туурвисан “Өмнөговь аймгийн Соёлын биет өвийн тойм” номыг худалдан авах зардалд 1 350 000 /Нэг сая гурван зуун тавь/ төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх хөрөнгийг Хурлын даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /Б.Галхүү/-д зөвшөөрсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



Х.СУГИР

463190051